



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/48

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагнал журам”, Аймгийн Засаг даргын 2017 оны А/160 тоот захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймгийн Засаг даргаас олгох шагналын журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хошой аварга малчин, улсын аварга малчин, улсын аварга тариаланч хамт олон, тариаланч, саальчин, алтан төлийн эзэнд хүндэтгэл үзүүлэхэд зарцуулагдах зардлыг нэгдүгээр, Аймгийн хошой аварга малчин, аварга малчин, Төр нийгмийн нэрт зүтгэлтэн Ж.Самбуугийн нэрэмжит Аймгийн залуу аварга малчин, аварга фермер, аварга саальчин, аварга хадланч, алтан төлийн эзэн, аварга тариаланч хамт олон, аварга тариаланчдад хүндэтгэл үзүүлэхэд зарцуулагдах зардлыг хоёрдугаар, аймгийн 2021 оны “Хөдөлмөрийн аварга”-уудад хүндэтгэл үзүүлэхэд зарцуулагдах зардлыг гуравдугаар, Мянгат малчдын “Батламж” хийлгэх зардлыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Шагналд зарцуулагдах 63,089,450 (жаран гурван сая наян есөн мянга дөрвөн зуун тавь) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (С.Магнайбаяр)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Ганхуяг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР